



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас/факс: (976-11) 329084  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2013.05.29 № 112223

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Ш.ТҮВДЭНДОРЖ ТАНАА


Банк бус санхүүгийн байгууллагуудын 2013 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулгыг хураангуй тайлан тэнцэл болон орлого үр дүнгийн тайлангийн хамт хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудас.

Хүндэтгэсэн,

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



001130

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2013 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.05.13

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 10 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 17 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосноор тайлант хугацааны эцэст нийт 229 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг өмнөх онтой харьцуулбал:

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацаа		
		2012 оны жилийн эцэст	2013 оны 1-р улиралд	өөрчлөлт
1	Тусгай зөвшөөрлийг сунгасан	40	10	
2	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	23	17	+17
3	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	6	-	-
4	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	4	-	-
5	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	2	-	-
6	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	212	229	17

ББСБ-уудын нийт тоо болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-

4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	18	38
8	2013. I улирал	229	25	18	39

2013 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тохиолдол байхгүй байна.

ББСБ-уудыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал: /Хүснэгт 4/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо		
		2012 оны IV улирал	2013 оны I улирал	
1	Зээл	171	187	
2	Факторингийн үйлчилгээ	12	12	
3	Төлбөрийн баталгаа гаргах	8	8	
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	-	
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5	
6	Гадаад валютын арилжаа:	Давхар эрхэлдэг	94	98
		Дагнан эрхэлдэг	38	39
7	Итгэлцлийн үйлчилгээ	18	18	
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	18	19	
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ <sup>1</sup> /Венчур хөрөнгө оруулалт/	1	-	

2012 оны жилийн эцэст банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 212 ББСБ-уудаас 80.7 хувь нь зээл, 44.3 хувь нь гадаад валютын арилжаа, 8.5 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэн явуулж байсан бөгөөд эдгээр нэр төрлийн үйл ажиллагаануудын хувьд 2013 оны 01 дүгээр улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаатай 16 ББСБ шинээр үүсгэн байгуулагдаж, гадаад валют арилжааны тусгай зөвшөөрлийг 2 ББСБ шинээр нэмж авч, хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 ББСБ хүчингүй болгосон байна.

2013 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар тайлан ирүүлбэл зохих нийт 229 ББСБ-аас 216 ББСБ тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, банк бус санхүүгийн итгэлцэл, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхэлж буй 23 ББСБ болон тайлан хүргүүлэх шаардлагатай 17 ББСБ нийт 40 ББСБ-д тайлангийн хариуг хүргүүлсэн.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны тайлант үеийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2013 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны байдалтай харуулбал: Үүнд /Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны I улирал	2013 оны I улирал	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	194	229	35
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	601	619	18
3	Ажиллагсадын тоо	1,088	1,257	169

<sup>1</sup>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг баталсан.

4	Салбар нэгжийн тоо	66	69	3
5	Харилцагчдын тоо	123,982	278,686	154,704
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	213,238,426.2	282,448,429.4	69,210,003.2
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>2.28%</b>	<b>2.13%</b>	<b>-0.15%</b>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	129,297,256.1	175,289,267.9	45,992,011.8
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>2.25%</b>	<b>2.36%</b>	<b>0.11%</b>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	142,722,873.3	181,185,590.1	38,462,716.8
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>19.35%</b>	<b>17.65%</b>	<b>-1.7%</b>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	121,072,993.1	149,371,005.0	28,298,011.9
<b>Банкны салбарт эзлэх хувь</b>		<b>45.04%</b>	<b>48.69%</b>	<b>3.65%</b>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	13,228,332.2	17,705,688.1	4,477,355.9
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/		61,573,072.4	
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/		39,362,368.5	
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/		22,210,703.8	
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	3,951,723.0	7,743,109.4	3,791,386.4
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	15,000,955.4	17,858,364.3	2,857,408.9
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	10,871,453.2	12,161,226.6	1,289,773.4
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	4,129,502.2	5,697,137.7	1,567,635.5


ББСБ-ын нийт актив өмнөх оны мөн үеэс 69.2 тэрбум төгрөгөөр буюу 32.5 хувиар өссөн байна.

2012 оны жилийн эцэст нийт актив 252,053,541.4 мянган төгрөг байсан бол 2013 оны 01 дүгээр улирлын байдлаар 282,448,429.4 мянган төгрөг болж 30,394,888.0 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна. Дээрх өсөлтөд тайлант үеийн ашиг 1.6 тэрбум төгрөг, дүрмийн сан 10.2 тэрбум төгрөгөөр /үүнээс тайлант улиралд шинээр тусгай зөвшөөрөл авсан 17 ББСБ-ын нийт дүрмийн сан 6.1 тэрбум төгрөг/ өссөн өсөлтүүд нөлөөлсөн.

2013 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 229 ББСБ байгаагийн 89.1 хувь буюу 204 ББСБ нь УБ хотод, 10.9 хувь буюу 25 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



**2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар орон нутагт төвтэй 25 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 10.9 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.3 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 2.7 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.2 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 2.9 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

				/Хүснэгт 8/
№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны I улирал	2013 оны I улирал	Өсөлт /+/, бууралт /-/
Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо		22	25	+3
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>11.34%</b>	<b>10.92%</b>	<b>-0.96%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	4,747,102.1	6,343,313.2	1,596,211.10
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>2.23%</b>	<b>2.25%</b>	<b>0.02%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,613,723.3	4,714,842.5	1,101,119.20
<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>		<b>2.79%</b>	<b>2.69%</b>	<b>-0.1%</b>
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/		25,851.0	
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	4,459,939.7	5,760,643.6	1,300,703.90
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>3.12%</b>	<b>3.18%</b>	<b>0.06%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,393,510.8	4,392,874.1	999,363.30
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>2.80%</b>	<b>2.94%</b>	<b>0.14%</b>

Хорооноос орон нутагт бичил санхүүгийн тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын үйл ажиллагааг дэмжиж байгаа бөгөөд 2013 оны 01 дүгээр улиралд 2 ББСБ шинээр үүсгэн байгуулагдсан ба энэ нь Баянхонгор аймагт зээлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахаар тусгай зөвшөөрөл авсан байна.

**2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.9 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 17.0 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 18.5 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 16.2 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 15.9 хувийг тус тус эзэлж байна.

				/Хүснэгт 9/
№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны I улирал	2013 оны I улирал	Өсөлт /+/, бууралт /-/
Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо		16	18	+2
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>8.25%</b>	<b>7.86%</b>	<b>0.39%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	36,191,807.0	47,191,695.3	10,999,888.30
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>16.97%</b>	<b>16.97%</b>	<b>0.0</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	21,475,520.7	32,508,320.6	11,032,799.90
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/		2,158,078.0	
<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>		<b>16.61%</b>	<b>18.54%</b>	<b>1.93%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	22,954,222.5	29,305,480.2	6,351,257.70
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>16.08%</b>	<b>16.17%</b>	<b>0.09%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	18,521,432.5	23,698,562.5	5,177,130.00
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>15.30%</b>	<b>15.86%</b>	<b>0.56%</b>

Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар Хорооноос гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн ББСБ-уудын 2013 оны 1-р улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

нэгжүүдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр нэмж олгохгүй байгаа ба мөн энэ хууль батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл авсан гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьд дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлэх талаар ирүүлж буй хүсэлтийн тоо эрс цөөрсөн байдалтай байна.

#### **2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:**

Тайлант хугацаанд буюу 2013оны 01 дүгээр улиралд нийт 17 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 17.6 хувь буюу 3 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 229 ББСБ байгаагийн 98 ББСБ буюу 42.8 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 39 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 39 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 17.0 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.8 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 4.4 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.5 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 11/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны I улирал	2013 оны I улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	39	39	-
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>20.10%</b>	<b>17.03%</b>	<b>-3.07%</b>
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,657,119.7	8,047,710.9	1,390,591.20
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>3.12%</b>	<b>2.85%</b>	<b>-0.27%</b>
B	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	6,609,090.8	7,915,996.5	1,306,905.70
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>4.63%</b>	<b>4.37%</b>	<b>-0.26%</b>
B	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,397,942.4	6,681,692.4	1,283,750.00
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>4.46%</b>	<b>4.47%</b>	<b>0.01%</b>

### **ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **3.1 Активын бүтэц, өөрчлөлт:**

Тайлант улиралд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 12/

№	ХӨРӨНГӨ	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	206,056,135.5	96.6	271,786,242.3	96.2	65,730,106.8	31.9
1	Мөнгөн хөрөнгө	61,763,225.8	29.0	70,304,239.2	24.9	8,541,013.4	13.8
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	3,265,667.3	1.5	9,289,012.2	3.3	6,023,344.9	184.4
3	Нийт зээл	129,297,256.1	60.6	175,289,267.9	62.1	45,992,011.8	35.6
	(Зээлийн эрсдлийн сан)	3,762,813.0	1.8	4,786,306.7	1.7	1,023,493.7	27.2
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	616,433.0	0.3	31,888.5	0.0	-584,544.5	-94.8
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0	-	-	0.0	0.0
5	Нийт факторингийн тооцооны авлага	943,535.0	0.4	842,431.9	0.3	-101,103.1	-10.7
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0	-	0.0	0.0	0.0


6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	860,090.9	0.4	940,330.1			
					0.3	80,239.2	9.3
7	Бусад хөрөнгө	12,789,790.4	6.0	19,875,379.1	7.0	7,085,588.7	55.4
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	282,950.0	0.1	-	0.0	-282,950.0	-100.0
<b>Б</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>7,182,290.6</b>	<b>3.4</b>	<b>10,662,187.1</b>	<b>3.8</b>	<b>3,479,896.5</b>	<b>48.5</b>
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	7,182,290.6	3.4	10,662,187.1	3.8	3,479,896.5	48.5
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	9,412,552.0	4.4	13,659,187.8	4.8	4,246,635.8	45.1
	(Хуримтлагдсан элэгдэл)	2,230,261.4	1.0	2,997,000.7	1.1	766,739.3	34.4
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>213,238,426.2</b>	<b>100.0</b>	<b>282,448,429.4</b>	<b>100.0</b>	<b>69,210,003.2</b>	<b>32.5</b>

2013 оны 01 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 229 компани нь 282,448,429.4 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2012 оны жилийн эцсийн байдлаас 30,394,888.0 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар, өмнөх оны тайлант үетэй харьцуулахад 69,210,003.2 мянган төгрөгөөр буюу 32.5 хувиар тус тус өссөн байна.


Тайлант хугацаанд нийт активын 96.2 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.8 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.

Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/график 3/



/График 4/



**3.2 Зээлийн багцын чанар:**

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 13/


№	Ангилал	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	121,504,543.5	94.0	163,994,349.9	93.6	42,489,806.4	35.0
2	Хугацаа хэтэрсэн	2,700,813.3	2.1	4,380,466.3	2.5	1,679,653.0	62.2
3	Чанаргүй зээл. Үүнээс	5,091,899.4	3.9	6,914,451.8	3.9	1,822,552.4	35.8
	Хэвийн бус	1,302,840.7	1.0	2,078,580.2	1.2	775,739.5	59.5
	Эргэлзээтэй	956,031.9	0.7	1,596,080.6	0.9	640,048.7	66.9
	Муу	2,833,026.8	2.2	3,239,791.0	1.8	406,764.2	14.4
	(Зээлийн эрсдлийн сан)	3,762,813.0	2.9	4,786,306.7	2.7	1,023,493.7	27.2
	<b>Нийт зээл</b>	<b>129,297,256.1</b>	<b>100.0</b>	<b>175,289,267.9</b>	<b>100.0</b>	<b>45,992,011.8</b>	<b>35.6</b>

2013 оны 01 дүгээр улирлын байдлаарх зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 35.6 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 35.0 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 62.2 хувиар, чанаргүй зээл 35.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 45,992,011.8 мянган төгрөгөөр буюу 35.6 хувиар нэмэгдсэн хэдий боловч зээлийн чанарт төдийлөн ахиц гараагүй байна гэж үзэж байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

/График 5/

**3.3 Зээлийн хүү:**

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 229 ББСБ-аас 81.7 хувь буюу 187 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.2 хувь, зээлийн дундаж доод хүү 2.4 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.3 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 6/

**ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

ББСБ-уудын 2013 оны 1 дүгээр улирал дахь нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 14/


№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	<b>Өр төлбөр</b>	<b>61,770,928.9</b>	<b>29.0%</b>	<b>90,764,085.49</b>	<b>32.1</b>	<b>28,993,156.6</b>	<b>46.9</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	13,228,332.2	6.2%	17,705,688.08	6.3	4,477,355.9	33.8
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	41,996,269.4	19.7%	61,573,072.35	21.8	19,576,803.0	46.6
3	Бусад эх үүсвэр	2,594,604.3	1.2%	3,742,215.62	1.3	1,147,611.3	44.2
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	-	-	-	-	-	-
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,588,476.3	1.2%	3,742,215.62	1.3	1,153,739.3	44.6
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	6,128.0	0.0%	-	-	-6,128.0	-100.0
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	-	-	-	-	-	-
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,951,723.0	1.9%	7,743,109.44	2.7	3,791,386.4	95.9
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>8,744,624.0</b>	<b>4.1%</b>	<b>10,498,753.83</b>	<b>3.7</b>	<b>1,754,129.8</b>	<b>20.1</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,285,330.0	1.1%	2,451,637.01	0.9	166,307.0	7.3
7	Бусад пассив	6,195,534.0	2.9%	8,046,689.02	2.8	1,851,155.0	29.9
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	263,760.0	0.1%	427.8	0.0	-263,332.2	-99.8
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>70,515,552.9</b>	<b>33.1%</b>	<b>101,262,839.32</b>	<b>35.9</b>	<b>30,747,286.4</b>	<b>43.6</b>
B	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>142,722,873.3</b>	<b>66.9%</b>	<b>181,185,590.11</b>	<b>64.1</b>	<b>38,462,716.8</b>	<b>26.9</b>
9	Хувьцаат капитал	121,072,993.1	56.8%	149,371,005.04	52.9	28,298,011.9	23.4
10	Бусад өмч	3,266,264.6	1.5%	6,462,028.75	2.3	3,195,764.2	97.8
11	Сангууд	1,249,891.3	0.6%	166,465.91	0.1	-1,083,425.4	-86.7

12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	14,474,726.9	6.8%	23,617,070.73	8.4	9,142,343.8	63.2
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,658,997.3	1.2%	1,569,019.68	0.6	-1,089,977.6	-41.0
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>213,238,426.2</b>	<b>100%</b>	<b>282,448,429.43</b>	<b>100.0</b>	<b>69,210,003.2</b>	<b>32.5</b>


2013 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт эх үүсвэрийн 35.9 хувийг нийт өр төлбөр, 64.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 43.6 хувиар, эзэмшигчдийн өмч 26.9 хувиар тус тус өссөн байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 7/



/График 8/



2013 оны 1 дүгээр улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.9 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 35.8 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 32.3 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ байгаагаас 2013 оны 1 дүгээр улирлын тайлант хугацаанд тэдгээрт нийтдээ 3,742,215.6 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй байна.

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар хоёрдогч өглөгтэй 6 ББСБ-д нийтдээ 1,569,019.7 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэлтэй байна.

### ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 18/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>9,519,801.7</b>	<b>63.5</b>	<b>14,253,653.5</b>	<b>79.8</b>	<b>4,733,851.8</b>	<b>49.7</b>
1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	8,858,783.0	59.1	13,473,139.6	75.4	4,614,356.6	52.1
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	237,059.0	1.6	357,725.4	2.0	120,666.4	50.9
	Үнэт цаасны хүүгийн орлого	0.0	0.0	3,524.6	0.0	3,524.6	100.0
	Бусад хүүгийн орлого	423,959.7	2.8	419,263.9	2.3	-4,695.8	-1.1
2	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО</b>	<b>4,952,819.7</b>	<b>33.0</b>	<b>3,312,790.5</b>	<b>18.6</b>	<b>-1,640,029.2</b>	<b>-33.1</b>
3	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>520,318.4</b>	<b>3.5</b>	<b>291,098.6</b>	<b>1.6</b>	<b>-229,219.8</b>	<b>-44.1</b>
4	<b>ЕРДИЙН БУС ОРЛОГО</b>	<b>8,015.5</b>	<b>0.1</b>	<b>821,7</b>	<b>0.0</b>	<b>-7,193.8</b>	<b>-89.7</b>
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>15,000,955.4</b>	<b>100.0</b>	<b>17,858,364.3</b>	<b>100.0</b>	<b>2,857,408.9</b>	<b>19.0</b>

Тайлант хугацааны нийт орлогын 79.8 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 49.7 хувиар өссөн/, 18.6 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 33.1 хувиар буурсан/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 19/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	<b>Арилжааны орлого</b>	<b>1,149,991.3</b>	<b>23.2</b>	<b>640,793.2</b>	<b>19.3</b>	<b>-509,198.1</b>	<b>-44.3</b>
1.1	Гадаад валютын арилжааны орлого	990,933.1	20.0	640,681.9	19.3	-350,251.2	-35.3
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	159,058.2	3.2	111.2	0.0	-158,947.0	-99.9
2	<b>Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого</b>	<b>2,715,224.5</b>	<b>54.8</b>	<b>1,497,792.7</b>	<b>45.2</b>	<b>-1,217,431.8</b>	<b>-44.8</b>
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	2,715,224.5	54.8	1,371,984.7	41.4	-1,343,239.8	-49.5
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-	125,808.1	3.8	125,808.1	100.0
3	<b>Санхүүгийн үйлчилгээний орлого</b>	<b>1,087,603.9</b>	<b>22.0</b>	<b>1,174,204.6</b>	<b>35.4</b>	<b>86,600.7</b>	<b>8.0</b>
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	-	-	4.4	0.0	4.4	100.0
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	124,554.9	2.5	133,454.7	4.0	8,899.8	7.1
3.4	Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	23,509.5	0.5	30,096.2	0.9	6,586.7	28.0

3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	432,253.0	8.7	841,734.7	25.4	409,481.7	94.7
3.7	Бусад	507,286.5	10.2	168,914.6	5.1	-338,371.9	-66.7
	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ</b>	<b>4,952,819.7</b>	<b>100.0</b>	<b>3,312,790.5</b>	<b>100.0</b>	<b>-1,640,029.2</b>	<b>-33.1</b>

2013 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 19.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 45.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 35.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байгаа ба нийт хүүгийн бус орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 20/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.3.31		2013.3.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,387,764.3	12.8	1,833,631.1	15.1	445,866.8	32.1
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	7,980,878.2	73.4	8,202,065.9	67.4	221,187.7	2.8
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	611,682.4	5.6	1,216,948.7	10.0	605,266.3	99.0
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	401,477.1	3.7	188,175.6	1.5	-213,301.5	-53.1
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	30.2	0.0	0.0	0.0	-30.2	-100.0
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	489,621.0	4.5	720,405.3	5.9	230,784.3	47.1
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>10,871,453.2</b>	<b>100.0</b>	<b>12,161,226.6</b>	<b>100.0</b>	<b>1,289,773.4</b>	<b>11.9</b>

2013 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөнөөс хүүгийн зардал 32.1 хувиар, хүүгийн бус зардал 2.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 99.0 хувиар, орлогын татварын зардал 47.1 хувиар тус тус өсч, үндсэн бус үйл ажиллагааны зардал 53.1 хувиар, ердийн бус зардал 100.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар, нийт зардал 11.9 хувиар тус тус өссөн байна.

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 5,697,137.7 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38.0 хувиар өссөн байна.


/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 21/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012.3.31	2013.3.31	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	15,000,955.4	17,858,364.3	2,857,408.9
2	НИЙТ ЗАРДАЛ	10,871,453.2	12,161,226.6	1,289,773.4
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	4,129,502.2	5,697,137.7	1,567,635.5

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 9/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн мөн ББСБ-уудын активын болон тооны өсөлт тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн байна.

### **ЗУРГАА. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Тайлант улирлын байдлаар Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 186 ББСБ бүрэн хангаж ажилласан, 43 ББСБ 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 181,188,646.2 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 205,707,344.7 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 87.2 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 88.1 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 63.5 хувь;

- түргэн борлогдох актив 64,277,159.6 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 74,004,430.6 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 86.9 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 6,084,107.0 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 181,188,646.2 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 3.36 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 17,705,688.1 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 181,188,646.2 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 9.8 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 3,642,306.2 мянган төгрөг, нийт актив 282,448,429.4 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.3 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,972,469.4 мянган төгрөгөөр байгуулбал зохицоо 19,069.0 мянган төгрөгөөр илүү буюу нийт 4,991,538.4 мянган төгрөгөөр байгуулсан байна.<sup>2</sup>

<sup>2</sup>Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

**НАЙМ. ДҮГНЭЛТ**

1. Тайлант жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 229 ББСБ-аас 216 ББСБ /98.7 хувь/ тайлангаа ирүүлсэн ба 13 ББСБ /5.7 хувь/ эхлэлтийн санхүүгийн тайлан болон өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс тайлангийн ирц сайжирсан байна.
2. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 69,210,003.2 мянган төгрөг буюу 32.4 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 45,992,011.8 мянган төгрөг буюу 35.6 хувь, эзэмшигчдийн өмч 38,462,716.8 мянган төгрөг буюу 26.9 хувь, нийт дүрмийн сан 28,298,011.9 мянган төгрөг буюу 23.4 хувиар тус тус өссөн байна.
3. ББСБ-уудын нийт актив 2013 оны 01 дүгээр улирлын байдлаар 282,448,429.4 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын */банкны салбарын нийт актив 13,286,021,873.7 мянган төгрөг/* 2.1 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 175,289,267.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн */банкны салбарын нийт зээл 7,431,908,697.0 мянган төгрөг/* 2.4 хувь, нийт дүрмийн сан 149,371,005.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн */банкны салбарын нийт дүрмийн сан 306,800,631.8 мянган төгрөг/* 45.7 хувьтай тус тус тэнцэж байна.
4. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант улиралд нийт 72 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 187 ББСБ-ын 38.5 хувийг эзэлж байна.

**ЁС. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ**

2013 онд дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн сан, нэгдсэн сүлжээг сайжруулах;
2. Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанкны ЗМС-нд холбогдсон ББСБ-уудын тоог нэмэгдүүлэх,
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах,
4. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг идэвхижүүлэх,
5. Орон нутгийн төлөөлөгч нартай нягт хамтран ажиллах,
6. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалт, зөвөлгөөг зохион байгуулах;
7. ББСБ-даас иргэдэд олгож буй зээлийн хүүгийн түвшинд нэгдсэн үнэлэлт дүгнэлт өгч, зээлийн хүүгийн бодлогод тавих хяналт, зохицуулалтын талаар бодлогын түвшинд асуудал боловсруулан Хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР**

31/03/2013

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НИЙТ		ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ		ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНТАЙ ХОЛБОГДОГ		ЗӨВХӨН ГАДААД ВАЛЮТЫН ЭРХТЭЙ		ХӨДӨӨ ОРОН НУТАГ	
		ХӨРӨНГӨ	ДҮН	ХУВЬ	ДҮН	ХУВЬ	ДҮН	ХУВЬ	ДҮН	ХУВЬ	ДҮН
A	Эргэлтийн хөрөнгө	271,786,242.31	96.23%	45,594,840.74	96.62%	163,469,759.34	96.33%	7,749,887.96	96.30%	5,851,825.95	92.25%
1	Мөнгөн хөрөнгө	70,304,239.20	24.89%	4,612,087.58	9.77%	20,319,127.44	11.97%	7,476,864.58	92.91%	953,351.79	15.03%
	Бэлэн мөнгө	35,423,754.62	12.54%	931,502.49	1.97%	7,420,695.70	4.37%	7,255,665.97	90.16%	693,108.12	10.93%
	Банкинд байршуулсан харилцах	15,531,740.70	5.50%	2,057,265.11	4.36%	9,771,498.67	5.76%	220,999.52	2.75%	258,192.61	4.07%
	Банкинд байршуулсан хадгаламж	5,281,165.23	1.87%	42,372.30	0.09%	1,526,825.03	0.90%	0.00	0.00%	2,051.06	0.03%
	Санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	12,628,671.00	4.47%	142,040.04	0.30%	161,200.39	0.09%	199.08	0.00%	0.00	0.00%
	Санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	1,438,907.64	0.51%	1,438,907.64	3.05%	1,438,907.64	0.85%	0.00	0.00%	0.00	0.00%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	9,289,012.24	3.29%	0.00	0.00%	2,056,038.33	1.21%	40,409.92	0.50%	53,680.14	0.85%
	Арилжааны үнэт цаас	185,577.98	0.07%	0.00	0.00%	73,604.00	0.04%	40,409.92	0.50%	19,092.14	0.30%
	Засгийн газрын	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Төв банкны	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Хувьцаа	112,973.98	0.04%	0.00	0.00%	1,000.00	0.00%	40,409.92	0.50%	19,092.14	0.30%
	Өрийн бичиг	72,604.00	0.03%	0.00	0.00%	72,604.00	0.04%	0.00	0.00%	0.00	0.00%
	Бусад	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	9,112,696.17	3.23%	0.00	0.00%	1,991,696.25	1.17%	0.00	0.00%	34,588.00	0.55%
	Засгийн газрын	1,000.00	0.00%	0.00	0.00%	1,000.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Төв банкны	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Хувьцаа	2,060,096.17	0.73%	0.00	0.00%	1,990,696.25	1.17%	0.00	0.00%	34,588.00	0.55%
	Өрийн бичиг	7,051,600.00	2.50%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Бусад	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%	0.00	0.00%
	(Хөрөнгө оруулалтын үнэт цаасны эрсдлийн сан)	9,261.92	0.00%	0.00	0.00%	9,261.92	0.01%	0.00	0.00%	0.00	0.00%
3	Нийт зээл	175,289,267.89	62.06%	32,508,320.61	68.89%	135,287,375.65	79.72%	0.00	0.00%	4,830,719.78	76.15%
	Зээл /цэврээр/	170,502,961.16	60.37%	30,948,835.68	65.58%	132,881,749.84	78.30%	0.00	0.00%	4,714,842.48	74.33%
